



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 01

Сүхбаатар

Г
“Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг
дээшлүүлэх жил” болгон зарлах тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 128 дугаар тогтооолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.4.3, 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх замаар төр төсвийн байгууллагын үйл ажиллагааны чадавхи, үр нөлөө, төрөөс иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 2017 оныг аймгийн хэмжээнд “Төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх жил” болгон зарласугай.
2. Зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг дээшлүүлж, ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллага, ажил албаныхаа онцлог нөхцөл байдалд тулгуурлан бодлого зорилт дэвшүүлсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг төр, төсвийн нийт байгууллагын төсвийн шууд захирагч наарт үүрэг болгосугай.
3. Зарласан жилийн ажлын биелэлтийг хянах, удирдлага зохицуулалтаар хангаж, үр дүнг тооцож ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ДАРГА

Ө.СУВДАА